

## **АГУУЛГА**

### **2.1 ХҮН АМЫН ӨСӨЛТ, БҮТЭЦ**

#### **2.1.1 ХҮН АМЫН ТОО**

#### **2.1.2 ХҮЙСИЙН ХАРЬЦАА**

#### **2.1.3 ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, ӨСӨЛТИЙН КОЭФФИЦИЕНТ**

#### **2.1.4 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ**

#### **2.1.5 ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН СУВАРГА**

#### **2.1.6 ХҮН АМЫН ЗҮЙН АЧААЛАЛ**

#### **2.1.7 ХҮН АМЫН НЯГТРАЛ**

### **2.2 ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТ**

### **2.3. ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ**

### **2.4 ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН**

### **2.5 ӨРХИЙН ТОО**

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 2.1.1 Хүн амын тоо сумаар, хүн амын өсөлтийн хувиар, 2014-2019 он

Хүснэгт.2.1.2 Хүн амын тоо насны бүлгээр, хүйсийн харьцаа, 2019 он

Хүснэгт.2.1.3Төрөлт, нас баралтын тоо, ердийн цэвэр өсөлт, 2006- 2019 он

Хүснэгт 2.3.1Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, сумаар, төрлөөр 2019 он

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 2.1.1 Хүн амын тоо мян.хүн, хүн амын өсөлтийн хувиар 2001-2019 он

Зураг 2.1.2 Хүйсийн харьцаа 2013-2019 он

Зураг 2.1.3 Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент, төрөлт, нас баралтын ерөнхий коэффициент 2010-2019 он

Зураг 2.1.4 Хүн амын дундаж наслалт, улс, аймгийн дүн, 2010-2019 он

Зураг 2.1.5 Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2010-2019 он

Зураг 2.1.6 Хүн амын нас хүйсийн суварга, 2019 он

Зураг 2.1.7 Хүн ам зүйн ачаалал, 2013- 2019 он

Зураг 2.1.8 Хүн амын нягтрал сумаар, 2019 он

Зураг 2.2.1 Гэрлэлт, цуцлалтын тоо, 2013- 2019 он

Зураг 2.3.1 Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдийн тоо, 2010-2019 он

Зураг 2.3.2 Өрх толгойлсон эхийн тоо, 2013-2019 он

Зураг 2.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрлөөр, хувиар, 2019 он

Зураг 2.4.1 Шилжин ирэгч, шилжин явагчийн тоо, 2013- 2019 он

Зураг 2.4.2 Шилжин ирсэн, явсан хүн ам, насны бүлгээр 2019 он

Зураг 2.5.1 Өрхийн тоо, өрхийн хэлбэрээр, 2019 он

Зураг 2.5.2 Өрхийн тоо 2013- 2019 он

Зураг 2.5.3 Өрхийн тоо, сумаар 2019 он

## 2.1 Хүн амын өсөлт, бүтэц

### 2.1.1 Хүн амын тоо

Аймгийн хүн амын тоо 2019 оны байдлаар 57.5 мянган хүн болж өмнөх оны мөн үеэс 801 (-1.3%) хүнээр буурсан байна. Нийт хүн амын 28649 эрэгтэйчүүд (49.9%), 28830 эмэгтэйчүүд (50.1%) эзэлж байна.

Зураг 2.1.1 Хүн амын тоо мян.хүн, хүн амын өсөлтийн хувиар 2001-2019 он



Хүснэгт 2.1.1 Хүн амын тоо сумаар, хүн амын өсөлтийн хувиар, 2014-2019 он

Сум	2014	2015	2016	2017	2018	2019	Өсөлтийн хувь
Алтай	2022	2102	2082	2063	2056	2056	0.0
Баян-Уул	3062	2984	3000	3002	3026	3006	-0.7
Бигэр	2148	2113	2139	2211	2243	2243	0.0
Бугат	2195	2186	2191	2168	2210	2156	-2.4
Дарив	1814	1819	1852	1844	1860	1772	-4.7
Дэлгэр	3022	3023	3060	3127	3146	3139	-0.2
Жаргалан	1736	1752	1785	1802	1826	1805	-1.2
Тайшир	1426	1470	1550	1606	1599	1619	1.3
Тонхил	2204	2142	2152	2197	2222	2232	0.5
Төгрөг	1972	2014	2054	2054	2034	2050	0.8
Халиун	2311	2367	2388	2407	2458	2420	-1.5
Хөхморьт	2320	2332	2379	2373	2367	2353	-0.6
Цогт	3387	3513	3549	3579	3585	3503	-2.3
Цээл	2102	2101	2109	2164	2207	2226	0.9
Чандмань	2139	2176	2180	2218	2247	2216	-1.4
Шарга	1980	1971	1937	1937	1936	1957	1.1
Эрдэнэ	2180	2151	2179	2219	2327	2282	-1.9
Есөнбулаг	18678	17802	18108	18470	18931	18444	-2.6
<b>Бүгд</b>	<b>56698</b>	<b>56018</b>	<b>56694</b>	<b>57441</b>	<b>58280</b>	<b>57479</b>	<b>-1.4</b>


Хүн амын тоог сумаар нь харахад Тайшир, Шарга, Тонхил, Цээл сумын хүн ам 1.3-0.9 хувиар, өсч бусад сумын хүн ам 0.6-4.7 хувиар буурсан байна.

### 2.1.2 Хүйсийн харьцаа

Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйн тоогоор илэрхийлэгддэг. Манай аймгийн хувьд 2019 онд төрөх үеийн хүйсийн харьцаа буюу шинэ төрсөн 100 эмэгтэй хүүхдэд 112 эрэгтэй хүүхэд ноогдож байна. Харин нийт хүн амд хүйсийн харьцаа 99.4 байна. Сүүлийн 7 жилийн үзүүлэлтээс харахад 2013 онд хүйсийн харьцаа 94.3 байснаа өссөөр 2019 онд 99.4 болсон байна.

$$\text{Хүйсийн харьцаа/sex ratio} = \frac{p_m}{p_w}$$

Зураг 2.1.2 Хүйсийн харьцаа 2013-2019 он



Шинэ төрсөн 100 охидод 104-106 хөвгүүд ноогддог зүй тогтол байдаг. Шинэ төрсөн хүүхдийн хүйсийн харьцааны энэ онцлогоос хамааран 10-14 хүртлэх насны хүүхдийн дотор хөвгүүд арай давамгайлж дараагийн насны бүлгүүдэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хүйсийн харьцаа ойролцоо түвшинд байж нас ахих тутамд эмэгтэйчүүд нь давамгайлдаг зүй тогтолтой. Манай аймгийн хувьд ч энэ зүй тогтол ажиглагдаж байна. Хүн амын насны бүтцийн өөрчлөлт нь төрөлт, нас баралттай нягт уялдаатай байдаг. Сүүлийн жилүүдэд төрөлт бага зэрэг өсөж байгаагаас суваргын суурь өргөссөн байна.

Хүснэгт.2.1.2 Хүн амын тоо насны бүлгээр, хүйсийн харьцаа, 2019 он

Насны бүлэг	Хүн амын тоо	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
<b>Бүгд</b>	57479	28649	28830	99.4
0-4	6204	3219	2985	107.8
5-9	6039	3122	2917	107.0
10-14	5338	2764	2574	107.4
15-19	4883	2521	2362	106.7
20-24	4840	2462	2378	103.5
25-29	4233	2156	2077	103.8
30-34	4339	2199	2140	102.8
35-39	4183	2109	2074	101.7
40-44	4089	2009	2080	96.6
45-49	3759	1902	1857	102.4
50-54	3136	1523	1613	94.4
55-59	2463	1128	1335	84.5
60-64	1655	725	930	78.0
65-69	843	328	515	63.7
70-74	565	179	386	46.4
75-79	509	190	319	59.6
80-84	253	76	177	42.9
85-89	114	27	87	31.0
90-94	25	7	18	38.9
95-99	7	2	5	40.0
100+	2	1	1	0


### 2.1.3 Хүн амын ердийн цэвэр өсөлт, өсөлтийн коэффициент

Энэ үзүүлэлт нь төрөлт нас баралтын тооноос шалтгаалан эерэг эсвэл сөрөг байж болно. 2018 оны байдлаар хүн амын ердийн цэвэр өсөлт, өсөлтийн коэффициент (ХАЕЦӨК) нь 17.8 байгаа нь 1000 хүн тутамд 18 хүн шинээр нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ үзүүлэлт нь төрөлтийн түвшин өндөр, нас баралтын түвшин бага байгаа үед хамгийн өндөр байдаг. Шилжих хөдөлгөөний нөлөөллийг оруулахгүй тооцдог үзүүлэлт юм.

Хүснэгт.2.1.3 Төрөлт, нас баралтын тоо, ердийн цэвэр өсөлт, 2006- 2019 он

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт
2006	1164	383	781
2007	1214	295	919
2008	1235	326	909
2009	1331	364	967
2010	1209	348	861
2011	1313	367	946
2012	1359	217	1142
2013	1435	284	1151
2014	1294	287	1007
2015	1265	295	970
2016	1208	348	860
2017	1221	292	929
2018	1366	335	1031
2019	1457	336	1121

Зураг 2.1.3 Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент, төрөлт, нас баралтын ерөнхий коэффициент 2010-2019 он




Сүүлийн 5 жилд 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. 2010 оноос хойш 10 жилийн хугацаанд 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 3.5 пунктээр өссөн байна.

## 2.1.4 Хүн амын дундаж наслалт

Аймгийн хүн амын дундаж наслалт 70.34 байгаа ба улсын дундаж наслалттай харьцуулахад 0.07-аар доогуур байна. Мөн дундаж наслалтыг хүйсээр нь авч үзвэл эрэгтэй улсын дундаж наслалттаас 0.99-оор, эмэгтэй 1.06-оор доогуур байна.

Зураг 2.1.4 Хүн амын дундаж наслалт, улс, аймгийн дүн, 2010-2019 он



Дундаж наслалтыг хүйсээр 2010 онтой харьцуулахад эмэгтэй хүнийх 5.02 насаар, эрэгтэй хүнийх 2.34 насаар нэмэгдсэн байна. Мөн эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 2.68 насаар илүү нэмэгдсэн нь харагдаж байна.

Зураг 2.1.5 Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2010-2019 он




Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эмэгтэй хүний дундаж наслалт 74.9 болж, өмнөх оноос 0.56 пунктээр, эрэгтэй хүний дундаж наслалт 65.37 болж, өмнөх оноос 0.28 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

## 2.1.5 Хүн амын нас хүйсийн суварга

Хүн амын нас, хүйсийн суваргаар хүн амын нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Суваргын баруун, зүүн талд хүйсээр ялган, насны бүлгийн хувьд хамгийн залуугаас эхлэн өсөх дарааллаар доороос дээш суварган хэлбэртэй байна. Хүн амын нас, хүйсийн суваргыг зурахдаа хүн амын бодит тоо болон нийт хүн амд эзлэх хувийн жингээр зурна. Хувийн жингээр зурахдаа нийт хүн амыг 100 хувь гэж тооцно. Аймгийн 2019 оны хүн амыг нас хүйсийн суваргаас харахад 0-39 насны хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байхад 40-с дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна. Аймгийн хэмжээнд 70 дээш насны 1475 өндөр настан байгаагийн 67.3 хувь нь эмэгтэйчүүд байна. 2019 оны эцсээр аймгийн хэмжээнд 97-с дээш насны 6 өндөр настан байгаа бөгөөд 4 эмэгтэй хүн байна

Зураг 2.1.6 Хүн амын нас хүйсийн суварга, 2019 он



Хүн амын 17.6 мянган хүн (30.6%) 0-14 насны хүүхэд, 35.9 мянган хүн (62.5%) 15-59 насны хөдөлмөрийн насны хүн ам, 6.9 мянган хүн ам (6.9%) 60 дээш насны хүн ам эзэлж 2018 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.5 пунктээр, 60 дээш насны хүн амын эзлэх хувь 0.3 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.8 пунктээр буурсан байна.

## 2.1.6 Хүн амын зүйн ачаалал

Хүн ам зүйн ачааллыг тооцохдоо тэжээгч насны бүлэг буюу 15-64 нас, тэжээлгэгч бүлэг буюу 15-аас доош, 64-с дээш насны хүн амыг хамруулан тооцдог. Энэ үзүүлэлт нь хөдөлмөрийн насны нийт хүн амд хөдөлмөрийн бус насны хэдэн хүн ноогдож буйг харуулна.

Зураг 2.1.7 Хүн ам зүйн ачаалал, 2013- 2019 он




Аймгийн хүн ам зүйн нийт ачаалал 2013 оноос 2.1, 2016 оноос 2.7 пунктээр өссөн байна. Хүн ам зүйн ачаалал нь өсч байгаа нь сөрөг үзүүлэлт юм. Ачааллыг хүүхэд, хөгшин насны бүлгээр тооцож үзвэл 2019 онд өмнөх оны мөн үеэс хүүхдийнх 1.2, хөгшид нь 0.4 пунктээр өсчээ.

## 2.1.7 Хүн амын нягтрал

Манай аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 141447 кв.км бөгөөд нэг км квадратад 0.4 хүн ноогдож байна. Хүн амын нягтралаар Есөнбулаг сум хамгийн өндөр буюу 1 кв.км-д 8.5 хүн ноогдож байна. Энэ нь аймгийн төв нь гэрэл цахилгаантай үйлдвэрлэл үйлчилгээ илүү хөгжсөн түүнийгээ дагаад хүн ам ихтэй, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ ч харьцангуй бага байгаатай холбоотой юм.

Зураг 2.1.8 Хүн амын нягтрал сумаар, 2019 он



## 2.2 Гэрлэлт, цуцлалт, хүүхэд үрчлэлт


Хүн амын гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн шинжлэх ухаанд гэрлэлт, салалт, бэлбэсрэлт, тусгаарлалт, дахин гэрлэлт зэрэг ухагдахуунуудын цогцоор илэрхийлэгддэг.

Батлуулсан гэр бүлтэй- Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “Батлуулсан гэр бүлтэй” буюу гэр бүлтэй гэнэ.

Салсан-Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүмүүсийг салсан гэнэ.

Манай аймгийн хувьд 2019 оны байдлаар гэрлэлт 336 болж өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар, цуцлалт 19 болж өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар өссөн байна. Хүүхэд үрчлэлт 24 байгаагийн эрэгтэй нь 12 хүүхэд, эмэгтэй хүүхэд 12 байна. Хүүхэд үрчлэлтийг насны бүлгээр нь авч үзвэл 14 хүүхэд (58.3%) 0-2 настай, 6 хүүхэд (25.0%) 3-6 настай, үлдсэн 4 хүүхэд (16.7%) нь 7 дээш настай хүүхэд байна.


Зураг 2.2.1 Гэрлэлт, цуцлалтын тоо, 2013- 2019 он




## 2.3. Хүн амын нийгмийн зарим үзүүлэлт

Аймгийн дүнгээр бүтэн өнчин 54, хагас өнчин 969 хүүхэд, арван найм хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн 931, ганц бие өндөр настан өрх 1399, өрх толгойлсон эцэг, эхийн тоо 2150, хөгжлийн бэрхшээлтэй 3016 хүн тус тус байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 20.3 хувь нь хөдөлгөөний согогтой, 8.1 хувь нь сонсгол, 3.1 хувь нь хэл ярианы согогтой, 3.9 хувь нь хавсарсан согогтой, 10.7 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 38.7 хувь нь бусад, 15.2 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.

Зураг 2.3.1 Бүтэн өнчин, хагас өнчин хүүхдийн тоо, 2013-2019 он



Зураг 2.3.2 Өрх толгойлсон эхийн тоо, 2013-2019 он




Өрх толгойлсон эхийн тоо 1835 болж өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 2.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, сумаар, төрлөөр 2019 он

Сум	Soum	Бүгд Total	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр: <i>By Forms of disability:</i>						
			Харааны	Хэл, ярианы	Сонсголын	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Хавсарсан	Бусад
Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	1048	97	21	100	195	120	21	494
Алтай	<i>Altai</i>	73	11	7	4	11	17	2	21
Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	183	17	4	5	38	39	20	60
Бигэр	<i>Biger</i>	101	10	1	10	23	22		35
Бугат	<i>Bugat</i>	125	14	2	7	31	22	12	37
Дарви	<i>Darib</i>	74	9		3	26	12	2	22
Дэлгэр	<i>Delger</i>	177	14	8	9	34	24	12	76
Жаргалан	<i>Jargalan</i>	102	9	9	11	14	24		35
Тайшир	<i>Taishir</i>	78	5	2	6	23	9		33
Тонхил	<i>Tonhil</i>	108	16	2	7	25	14	3	41
Төгрөг	<i>Tugrug</i>	113	20	4	10	22	3	5	49
Халиун	<i>Haliun</i>	143	19	11	9	28	19	8	49
Хөхморьт	<i>Huhmorit</i>	110	13	4	6	22	21	5	39
Цогт	<i>Tsogt</i>	160	17	5	14	35	35	3	51
Цээл	<i>Tseel</i>	69	10	5	10	14	4	2	24
Чандмана	<i>Chandmani</i>	93	10		13	18	22	23	7
Шарга	<i>Sharga</i>	137	19	2	7	32	24		53
Эрдэнэ	<i>Erdene</i>	122	14	5	13	20	28	1	41
Дүн	<i>Total</i>	3016	324	92	244	611	459	119	1167

Зураг 2.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрлөөр, хувиар, 2019 он



## 2.4 Шилжилт хөдөлгөөн

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн дийлэнхдээ нийслэл Улаанбаатар хотруу чиглэж байгаа ба манай аймгийн хувьд ч нийт шилжин явагчдын ихэнх нь Улаанбаатар хотруу шилжиж байгаа билээ.

### Шилжин ирсэн хүн ам

390 шилжин ирсэн хүмүүсийн ихэнх нь буюу 187 хүн (47.9%) нь Улаанбаатар хотоос ирсэн байна. Шилжин ирсэн хүмүүсийн 186 хүн (47.7%) эмэгтэйчүүд байна. Шилжин ирсэн хүний тоо өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар буурсан байна.

### Шилжин явсан хүн ам


Энэ онд 874 шилжин явагч байгаагийн 466 хүн (53.3%) нь зөвхөн Улаанбаатар хотруу явсан байна. Шилжин явсан хүмүүсийн 465 хүн (53.2%) эмэгтэйчүүд байна. Шилжин явсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 86.7 хувиар өссөн байна.

Зураг 2.4.1 Шилжин ирэгч, шилжин явагчийн тоо, 2013- 2019 он



Энэ нь аж үйлдвэр, үйлчилгээний салбар хот суурин газар илүү хөгжсөн, их дээд сургуулиуд нь Улаанбаатар хотод олноороо байдаг, мөн нийгэм эдийн засгийн хөгжлийн өсөлт хөдөө орон нутагтай харьцуулахад илүү байгаа зэргээс шалтгаалж байгаа боловуу. Шилжигчдийн хүйсийн харьцаа ерөнхийдөө тэнцвэргүй байгаа ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр шилжилт хөдөлгөөнд оролцох хандлагатай байна.


Зураг 2.4.2 Шилжин ирсэн, явсан хүн ам, насны бүлгээр 2019 он




## 5 Өрхийн тоо

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 10.4 хувиар өссөний дотор хотын өрх 10.2 хувиар, хөдөөгийн өрх 10.5 хувиар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд 16.1 мянган өрх тоологдсоноос 71.2 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 13.7 хувь нь нийлмэл ам бүлтэй, 14.7 хувь нь ганц бие, 0.4 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.


Зураг 2.5.2 Өрхийн тоо, өрхийн хэлбэрээр, 2019 он



Өрхийн тоо 2013- 2019 он



Зураг 2.5.3 Өрхийн тоо, сумаар 2019 он



Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь 2010 оны улсын дундаж тоотой ижил байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 1-2 ам бүлтэй өрх хотод 4.5 пунктээр, хөдөөд 5.1 пунктээр өмнөх тооллогын дүнгээс нэмэгдсэн байна. Үүнийг шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид, болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм.